




GOVI

ГОВЬ ХК-ИЙН 2024 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


/Тайлант хугацаа: 2024.01.01-09.30/

1.	КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА	3
2.	САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	11
3.	2024 ОНЫ I-III УЛИРАЛД БИД	22
4.	ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	32
5.	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	46



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА



GOBI

ГОВЬ ХК нь 100 хувь Монгол ноолуураар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний ууган компани бөгөөд олон зууныг дамжин уламжлагдан ирсэн ур ухааныг орчин үеийн үйлдвэрлэлийн дэвшилтэт технологитой хослуулан тав тухтай, удаан эдэлгээтэй загварууд үйлдвэрлэн хэрэглэгчдэдээ хүргэдэг билээ.

Бид нүүдэлчин соёлтой малчин ардтайгаа хамтран ажиллаж, Улаанбаатар хот дахь үйлдвэртээ бүх бүтээгдэхүүнээ хариуцлагатай үйлдвэрлэдэг.

70 гаруй хувь нь эмэгтэйчүүдээс бүрдсэн 1,700 орчим ажилтантай ГОВЬ компани нь эх орондоо ажлын байр бий болгож, дэлхий дахинд хамгийн зөөлөн, тансаг ноолууран бүтээгдэхүүнийг бахархалтайгаар хүргэж өдгөө 43 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна.




ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ



Жилд нийт **2.5 сая ширхэг** бэлэн бүтээгдэхүүн

Бид дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэхийн тулд Монгол Улсын төдийгүй олон улсын стандартын шаардлагыг хангаж, удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулж байна.



ГОВЬ ХК


GOBI


GOBI

Бүх насныханд зориулсан сонгодог загварын хувцас, аксессуар болон гэр ахуйн бүтээгдэхүүнээр дэлхийд танигдсан **GOBI** брэнд

GOBI
ORGANIC

Байгалийн үндсэн дөрвөн өнгийн ноолуурыг химийн будаг болон цайруулагч ашиглалгүйгээр урласан **GOBI ORGANIC** брэнд

GOBI
KIDS

Хүүхдийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр дулаахан, таатай, хөнгөн мэдрэмжийг бэлэглэх загварлаг үрсийн **GOBI KIDS** брэнд


GOYO
CASHMERE

Орчин үеийн загварын чиг хандлагад нийцүүлэн бүтээлээ урладаг, тод өнгө, загваруудаар эрх чөлөөт байдлыг илэрхийлсэн шинэ залуу үеийн **GOYO** брэнд





YAMA
cashmere by GOBI

Дэлхийн шилдэг дизайнерууд ур ухаанаа шингээн урласан дээд зэргийн чанартай, тансаг зэрэглэлийн **YAMA** брэнд

REBRANDING

GOBI

Олон улсын зах зээлд брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebranding хийх ажлыг 2024 оны эхнээс хийж эхэлсэн бөгөөд 7-р сарын 2-ны өдөр GOBI брэндийн шинэ өнгө төрхийг танилцуулж, логогоо шинэчилж, анх удаагаа брэндийн бэлгэ тэмдэгтэй болов.



GOBI-ийн шинэчлэгдсэн бэлгэ тэмдэг нь ноолууран бүтээгдэхүүн бий болох үйл явцын гол оролцогч талуудыг илтгэнэ.

Truly Mongolian.

I-р улиралд



БНСУ-ын сүлжмэлийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн дамжлага болон оёх, индүүдэх технологийг сурч, туршлага судлав.



Монгол-Солонгосын политехникийн коллежтэй “Говь Академи”-ийн хүрээнд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.



3-р сарын 1-ний өдөр Гүйцэтгэх захирлыг шинээр томилох ёслолын арга хэмжээ болж, Гүйцэтгэх захирлаар Б.Амарсайхан томилогдов.



SAP S/4 HANA ERP систем Co-Live болов.



UNIDO-ийн тэтгэлгээр Олон улсын "OEKO-TEX STANDARD 100" гэрчилгээг Монголд анх удаа бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авав.



Азийн Хөгжлийн Банктай хамтран “Уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төсөл”-ийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны гэрээг үзэглэв.



Хөнгөн аж үйлдвэрийн 90 жилийн ойг угтсан нийт ажилтны баярын хурал зохион байгуулав.



Дотоод хяналтын лаборатори нь итгэмжлэгдсэн сорилтын лаборатори болов.

II-р улиралд



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4-р сарын 29-ний өдөр зохион байгуулж, компанийн үйл ажиллагаа ба санхүү үр дүнгийн тайлан, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг шинээр сонгов.



Дэлхийн №1 дэвшилтэт технологи бүхий Итали улсын “BIGAGLI” мөлхөө ээрэх машиныг амжилттай суурилуулж ээрмэлийн үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлэв.



“Flagship Store” буюу төв дэлгүүр өнгө төрхөө шинэчлэн нээлтээ хийв. Албан ёсны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хүрэлцэн ирсэн зочид үйлдвэрээр аялан бүтээгдэхүүн бий болох үйл явцтай танилцлаа.



Олон улсад брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebranding-ийг оны эхнээс хийж эхэлсэн бөгөөд GOBb брэндийн бэлгэ тэмдэг, шинэчилсэн лого ба шинэ өнгө төрхийг танилцуулав.

III-р улиралд




Хувьцаа эзэмшигчдийн ээлжит үйлдвэртэй танилцах аяллыг амжилттай зохион байгууллаа. Компанийн удирдлага ба ТУЗ-ийн гишүүдийн төлөөлөл хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч уулзлаа.



Монгол Улсын хөнгөн аж үйлдвэрийн салбарын түүхэнд анх удаа MES (Manufacturing Execution System) болон Conveyor Belt (дамжлагын систем)-ийг нэвтрүүлэх үйл явцыг эхлүүллээ.



Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр Говь ХК-ийн үйлдвэрт хүрэлцэн ирж үйл ажиллагаатай танилцлаа.




Санхүүгийн Зохицуулах Хорооноос компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг 2024 оны хагас жилийн байдлаар үнэлэн баталгаажуулахад Говь ХК 2024 оны хагас жилийн байдлаар 98.6% болж нээлттэй хувьцаат компаниудыг дахин тэргүүллээ.




САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/





ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2023.09.30	2024.09.30		
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Өмнөх оноос өөрчлөлт	
				тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	<i>сая.төг</i>	166,376	167,916	1,541	1%
Дотоод борлуулалт	<i>сая.төг</i>	103,615	114,208	10,593	10%
Экспорт борлуулалт	<i>сая.төг</i>	39,860	44,394	4,534	11%
Гадаад борлуулалт	<i>сая.төг</i>	22,901	9,315	(13,586)	-59%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	<i>мян.ширхэг</i>	740	726	(14)	-2%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	<i>сая.төг</i>	86,584	95,073	8,489	10%
НИЙТ АШИГ	<i>сая.төг</i>	79,792	72,843	(6,949)	-9%
Нийт ашгийн хувь	<i>хувь</i>	48%	43%		-5%
Үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	58,066	53,270	(4,796)	-8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	<i>сая.төг</i>	21,725	19,573	(2,153)	-10%
Үйл ажиллагааны ашгийн хувь	<i>хувь</i>	13%	12%		-1%
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	<i>сая.төг</i>	(1,641)	299	1,940	118%
Татварын өмнөх ашиг	<i>сая.төг</i>	(2,881)	(2,996)	(115)	-4%
ЦЭВЭР АШИГ	<i>сая.төг</i>	(3,883)	(5,098)	(1,215)	-31%
Цэвэр ашгийн хувь	<i>хувь</i>	-2%	-3%		-1%
Нийт үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	144,650	148,344	3,693	3%
ҮЙЛДВЭРЛЭЛ	<i>мян.ширхэг</i>	757	790	33	4%
Сүлжмэл бүтээгдэхүүн	<i>мян.ширхэг</i>	545	517	(28)	-5%
Нэхмэл бүтээгдэхүүн	<i>мян.ширхэг</i>	186	251	64	35%
Оёмол бүтээгдэхүүн	<i>мян.ширхэг</i>	26	23	(3)	-13%
Пальто	<i>мян.ширхэг</i>	13	12	(1)	-6%
Пиджак	<i>мян.ширхэг</i>	4	4	(0)	-1%
Ээрмэл утас	<i>тонн</i>	204	164	(40)	-20%
АЖИЛТНУУДЫН ТОО	<i>хүн</i>	1,668	1,656	(12)	-1%
Нэг ажилтанд ногдох орлого	<i>сая.төг</i>	100	101	2	2%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	<i>сая.төг</i>	3,162	15,561	12,399	392%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<i>сая.төг</i>	337,462	352,261	14,799	4%
Банкны зээл	<i>сая.төг</i>	258,908	280,246	21,337	8%
НИЙТ ХӨРӨНГӨ	<i>сая.төг</i>	337,462	347,450	9,988	3%
Бараа материал	<i>сая.төг</i>	163,243	155,512	(7,731)	-5%
МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ	<i>сая.төг</i>	13,548	4,744	(8,805)	-65%
Үүнээс: Гадаад маркетинг	<i>сая.төг</i>	12,051	3,519	(8,533)	-71%

Санхүүжүүлэгчийн нэр	Валют	Дуусах хугацаа	2023.12.31		2024.09.30	
			(мян.валют)	(мян.төг)	(мян.валют)	(мян.төг)
Банкны зээл						
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2025	-	13,333,333	-	5,833,333
Голомт банк (Зээлийн шугам)	MNT	2026	-	48,950,000	-	9,600,000
Голомт банк (Богино хугацаат зээл)	USD	2026	-	-	\$ 2,527	8,545,351
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	-	-	9,500,000
Хаан банк (Зээлийн шугам)	MNT	2025	-	6,500,000	-	2,000,000
Хаан банк (Урт хугацаат зээл)	MNT	2024	-	4,202,775	-	-
Хаан банк (Богино хугацаат зээл)	MNT	2024	-	10,000,000	-	-
Хас банк (Зээлийн шугам)	USD	2026	-	-	\$ 11,840	40,032,461
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2024	-	16,666,667	-	-
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	-	-	10,000,000
Ариг банк (Богино хугацаат зээл)	MNT	2024	-	14,500,000	-	-
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	-	-	\$ 18,000	60,860,160
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 12,000	40,928,280	\$ 12,000	40,573,440
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 8,000	30,333,280	€ 8,000	30,109,520
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 14,000	53,083,240	€ 14,000	50,691,660
Нийт /Банкны зээл/				238,497,575		280,245,926
Бондын санхүүжилт						
Бонд (Богино хугацаат зээл) *	USD	2025	-	-	\$ 3,250	10,988,640
Нийт санхүүжилт				238,497,575		291,234,566

* Говь ХК нь “Говь Бонд 2” санхүүжилт татах ажлын хүрээнд 2024 оны 04-р сарын 23-ны өдөр эрх бүхий байгууллагын тогтоолоор хаалттай хүрээнд эргэлтийн хөрөнгө, дахин санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх зорилгоор 12 сарын хугацаатай, жилийн 8.5%-ийн купонтой 16,800,000 ам.долларын бонд гаргах зөвшөөрөл авсан бөгөөд 2024 оны 09-р сарын 30-ны өдрийн байдлаар 3,250,000 ам.долларын бондыг хөрөнгө оруулагчдаас татсан байна.

Монгол банкны ханш /төг/

	2023.12.31	2024.09.30
USD	3,410.69	3,381.12
EUR	3,791.66	3,763.69

БОРЛУУЛАЛТ
114.2
тэрбум төгрөг

103.6



2023.09.30




2024.09.30


↑10%

2024 оны 3-р улирлын байдлаар дотоод зах зээл 114.2 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оны мөн үеэс 10% өсөлтийг үзүүлэв.

БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



2023.09.30




2024.09.30

■ Жуулчид
■ Дотоод

Дотоод зах зээлийн борлуулалтыг бүтцээр нь авч үзвэл жуулчдын борлуулалт үнийн дүнгээр 46%-ийг эзэлж байна.

БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН /мян.шир/



Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхгийг нэр төрлөөр нь дэлгэрүүлж харвал гутал 6,000 ширхэг борлуулсан нь **382%** өссөн байна.



Хими цэвэрлэгээ, нөхөн засвар хүлээн авах шинэ салбарыг И-Мартын Хан-Уул салбар дотор нээсэн.

2024.01



VIP хэрэглэгч нар, аялал жуулчлалын компаниудын удирдлагуудад FW24 коллекцийг танилцуулах арга хэмжээг зохион байгуулав.

2024.02



Коллекцийн танилцуулгын үеэр ирсэн санал хүсэлтүүд дээр үндэслэн дэлгүүр дээрх Styling, Window display, бүтээгдэхүүний өрөлтийг иж бүрэн лүүкээр бүрдүүлдэг болсон.

2024.02



Дэлгүүрүүдийн POS системийг шинэчлэн нэвтрүүлэв.

2024.03



Аялал жуулчлалын улирлын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж хөтөч, жолооч, аялалын компаниудын төлөөлөл бүхий 217 зочинд хамтран ажиллах төлөвлөгөөгөө танилцуулж мэдээлэл хүргэв.

2024.03



Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүр /Flagship Store/-ийн үндсэн тасгийн засвар, шинэчлэлийг хийв.

2024.05



Flagship Store-ийн нээлтийн үйл ажиллагааг хийн, үйлдвэр дэх загварын шоуг зохион байгуулав.

2024.06




Үйлдвэрийг Flagship Store-той холбосон хүзүүвчийг хийн ашиглалтад оруулав.

2024.06


Rebranding ажлын хүрээнд

Төв цэнгэлдэх хүрээлэнд 143 ширхэг гэрэлт самбар, худдаасан хэвлэл болон LED дэлгэцэнд шинэ лого бүхий сурталчилгааг 2025 оны 06-р сарын 30 хүртэл байршуулав.



Төв дэлгүүр болон Галлериа салбаруудын гадна, дотор хаягжилтуудыг шинэчилж дуусгав.





2024 оны 3-р улирлын байдлаар экспортын зах зээл 37 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлж, 44.4 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 11% өсөлттэй байв.



2024 оны 3-р улирлын байдлаар **5** улсын **9** хотод **10** франчайз дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байна.



Экспортын борлуулалтын газраас үйлдвэр, үйлдвэр удирдлагын багтай хамтран үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх туршлага судлах зорилгоор БНСУ-ын сүлжмэлийн үйлдвэрт ажиллаж БНСУ-ын сүлжмэлийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн дамжлага болон оёх, индүүдэх технологийн туршлага хуримтлууллаа.


GOBI | NP digital

NPDI x GOBI
ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаад борлуулалтын зах зээлд 2023 оноос эхлэн SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах дээр анхааран үе шаттай арга хэмжээг аван ажиллаж байна.

2024 оны 1-р сараас эхлэх NPDI Agency-тэй хамтын ажиллагааг эхлүүлсэн бөгөөд шинэ түлхүүр үгсийн судалгааг хамтран хийж, хэрэгжүүлж эхэлсэн.

БОРЛУУЛАЛТ
9.3
тэрбум төгрөг



Гадаад зах зээлийн хувьд 2024 онд маркетингийн зардлаа бууруулж, илүү брэндинг-д чиглэсэн маркетинг хийж, органик өсөлтийг дэмжин ажиллаж байна. Өөрөөр хэлбэл 2024 онд борлуулалтын өсөлтөөс илүү ашигт ажиллагааг сайжруулахад анхаарч байна. Үүнтэй холбоотой 3-р улирлын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс маркетингийн зардлыг 71%-аар бууруулснаар борлуулалт 59%-аар буурсан ч алдагдлын хэмжээг өнгөрсөн оны мөн үеэс 50%-аар бууруулж чадсан.

90,000+

Characters бүхий text хэлбэрийн контент шинээр оруулсан

40+

Онлайн уулзалт, хурлуудыг зохион байгуулсан

150+

Task-ууд болон засваруудыг вебсайт дээр оруулсан

+96.9%

Топ 10 түлхүүр үгсийн тооны өсөлт

+49.1%

Органик хандалтын өсөлт

2024 оны I-III улиралд хамтран ажилласан:

**Инфлүэнсэр
Дижитал сэтгүүл
Алдартан
Сэтгүүл & Хэвлэл
Сошиал медиа**

**Блог
Бусад**

**Сэтгэл ханамжийн
судалгааны үр дүн**

PR: 97, Internal: 32

Rollacoaster: :1

VIP: 4

Онлайн: 92 Хэвлэл: 10

Instagram: 139 posts/ 552 stories

Facebook: 143 posts/ 274 stories

Tiktok: 38 posts

Linkedin: 34 posts

YouTube: 59 posts

Pinterest: 68 posts

39

N1 Судалгаа (Топ 50 худалдан авагч)

Rebranding кампанит ажил (Топ 14 инфлүэнсэр gifting)

03.18-04.20 хийгдсэн (86.5%)

06.20-07.20 хийгдсэн (87.0%)



@rollacoaster, 298K
Digital magazine, UK



@Pamelaanderson, 3.4M
Celebrity



@Asap12vy, 391K
Celebrity, US



@julienpicket, 128K
Influencer, USA




@herstyleboard, 672K
Influencer, DE



@laurengiraldo, 1M
Influencer, US





**2024 ОНЫ
I-III УЛИРАЛД
БИД**


Компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн 2023 онд Product Lifecycle Management (PLM) системийг нэвтрүүлсэн бол 2024 оны 3-р сараас SAP S/4 HANA Enterprise Resource Management (ERP) системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн.

Мөн INA Manufacturing Execution System (MES) системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2024 оны 7 сараас эхлүүлсэн бөгөөд 2025 оны 1-р сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү системийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр Говь ХК-ийн Сүлжмэл болон Оёмолын үйлдвэрүүдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэгж бүтээгдэхүүний үр ашиг, дамжлага дундын мэдээлэл, үйлдвэрлэл дундын чанар, мөшгөлт, үйлдвэрлэлтийн тухайн цаг үеийн өгөгдөл мэдээлэл, хэвийн үйл ажиллагааны хяналт удирдлага зэрэг олон үйл ажиллагааны ашигт ажиллагааг улам сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд томоохон дэвшил авчрах юм.

Гол хүрэх үр дүнгүүд:

- Үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмж нэмэгдүүлэх
- Бүтээгдэхүүний чанар сайжруулах
- Үйлдвэрлэлийн процессын сайжруулалт
- Хяналтын үйл ажиллагаа нэмэгдэх
- Ажилтнуудын үр чадвар нэмэгдэх



- Санхүүгийн удирдлага сайжруулалт
- Үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэх
- Эрсдэлийг удирдах
- Бодит дүн шинжилгээ
- Нэгдсэн процесс
- Бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх хугацаа богиносох
- Бүтээгдэхүүний хөгжүүлэлт сайжрах
- Загварын түүхэн архив үүсэх



GOBI & ORGANIC FW 24/25

- Компанийн дотоод ажилтнууд, VIP үйлчлүүлэгч, Хувьцаа эзэмшигч, Аялал жуулчлалын компаниудын төлөөлөл, Харилцагч зэрэг нийт 107 зочдод 4 өдрийн 7 удаагийн танилцуулгыг хийсэн.
- Энэ оны IV-р улирлын эхэнд худалдаанд гаргахаар төлөвлөсөн

III-р улиралд дараах коллекцуудыг компанийн нийт дотоод зах зээл хариуцсан ажилтнуудад танилцуулж 2025 оны I-р улиралд худалдаанд гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

- Cashmere Reborn
- Responsible Cashmere
- Gobi SS25
- Organic SS25 коллекц

Үргэлжлүүлэн бид Giorgio Spina дизайнертай хамтран GOBI & ORGANIC FW 25/26 коллекцууд дээр ажиллаж байна.



2024 оны I - III улиралд:

- Үндсэн **4**, капсул **12** коллекц болон
- Шинэ нэр төрлийн **9** бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ танилцуулав.

I-р улиралд хэрэглэгчдэд хүргэсэн коллекц, бүтээгдэхүүнүүд



ЦАГААН САРЫН
КАПСУЛ КОЛЛЕКЦ



TRENDY COATS
КАПСУЛ КОЛЛЕКЦ



МАРТ 8
КАПСУЛ КОЛЛЕКЦ



LIGHT BEINGS SS24
ORGANIC КОЛЛЕКЦ



SPORT CASUAL
КАПСУЛ КОЛЛЕКЦ



ГОЁО FW 23
2-Р ХЭСЭГ



CASHMERE KNITTED
SNEAKERS
ШИНЭ ӨНГӨ



НООЛУУРАН
САРАВЧТАЙ МАЛГАЙ



“ДОМГИЙН АМЬТАД”
БАРЛАСАН ШААЛБ



CASHMERE SNEAKERS
ШИНЭ ЗАГВАР

II-р улиралд хэрэглэгчдэд хүргэсэн коллекц, бүтээгдэхүүнүүд



MATERNITY
КАПСУЛ КОЛЛЕКЦ



RESPONSIBLE CASHMERE
КАПСУЛ КОЛЛЕКЦ



GOBI LIGHT BEINGS
SS25 КОЛЛЕКЦ



NEW BORN
КАПСУЛ КОЛЛЕКЦ



CASHMERE REBORN
КАПСУЛ КОЛЛЕКЦ



KIDS SS24
КОЛЛЕКЦ



ЗУРААЧИДТАЙ
ХАМТАРСАН
БҮТЭЭЛҮҮД



НООЛУУРАН
BALLERINA ГУТАЛ



ШИНЭ ТӨРЛИЙН
ХАТГАМАЛТАЙ
ПИДЖАК



НААДАМ 2024
КАПСУЛ КОЛЛЕКЦ

III-р улиралд хэрэглэгчдэд хүргэсэн коллекц, бүтээгдэхүүнүүд



CASHMERE LOAFERS
ГУТАЛ



ORGANIC F/W 24-25 "SEE
THROUGH" КОЛЛЕКЦ



CASHMERE MULE
ГУТАЛ



ХҮҮХДИЙН НООЛУУРАН
ГУТАЛ



"ОГТОРГУЙН ОД ЭРХЭС"
БАРЛАСАН ШААЛЬ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Runway

- Жуулчны улирал нээлт
- Хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойн баяр
- Mongolian fashion week
- Төв дэлгүүрийн албан ёсны нээлтийн Runway Show

Styling

- Худалдаанд гарч буй шинэ коллекциуд
- Цуврал стилл бүрдүүлэлт видео контент

ОНЦЛОХ ЗАХИАЛГУУД



Ерөнхийлөгчийн тамгын газрын хүндэтгэлийн захиалгуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнээс дурдвал:

- Бутаны Хаант Улсын Эзэн Хааны айлчлалтай холбоотой “Хааны гэр бүлд” бэлэг
- Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын бэлэг
- Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхийлөгч А.Г.Лукашенкогийн айлчлалын бэлэг
- Бүгд Найрамдах Киргиз Улсын Парламентын дарга Нурланбек Шакиевийн айлчлалын бэлэг
- Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгчийн бэлэг
- НҮБ-ийн орлогч дарга Amina J.Mohammed айлчлал бэлэг
- Бүгд Найрамдах Киргиз улсын тэргүүн хатагтай айлчлал бэлэг
- Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгчийн айлчлал бэлэг
- Швейцарын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн айлчлал бэлэг
- Бүгд Найрамдах Словени Улсын Ерөнхийлөгчийн айлчлал бэлэг

ШИНЭЭР САНААЧИЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД, ҮР ДҮН



- 2023 онд 100% ноолууран малгайг хөгжүүлэлт хийж эхлэн 2024 оны 1 дүгээр улиралд худалдаанд гаргав.
- Whole garment 8L машинд тулгуурласан шинэ төрлийн зузаан оёдолгүй загварууд хөгжүүлэн худалдаанд анхлан гаргав.
- Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн болох Vulcanized Ултай Sneakers болон ноолууран Ballerina-г 2024 оны 2 дугаар улиралд худалдаанд гаргав. Ноолууран Ballerina нь амьсгалдаг технологиор бүтээсэн тул хөлийг халууцуулахгүй агаарыг бүрэн нэвтрүүлэх боломжтойгоороо онцлог тул хэрэглэгчдийн таашаалд өндрөөр нийцэж байна.
- Шинэ төрлийн бүтээгдэхүүн болох ноолууран цүнхний хөгжүүлэлтийг хийн ажиллаж байна.
- Gobi FW 24/25 коллекцид зориулан шинээр 3 төрлийн драп хөгжүүлэлт хийн гарган авсан.
- Хүүхдийн гутал болон Үүсэн ултай, нэхий дотортой “Cashmere Mule” гутлыг хэрэглэгчдэд хүргэв.





III-р улиралд

16

GOBI FW, Naadam Collection, Cashmere shoes, Bundle activations, Tennis looks, Back To School

Rebranding, Package, In-Store communication, Roll-Out

КОЛЛЕКЦИ БОЛОН ИДЭВХИЖҮҮЛЭЛТ ЗУРАГ АВАЛТ

REBRANDING

10


No Photo, FW Collections CN & EU, gobi.mn, Organic FW, EU Basics

Зураг болон бичлэг

530

СТАНДАРТ ЗУРАГ АВАЛТ

ГРАФИК ЗАХИАЛГАТ АЖЛУУД



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА



“Шинэ ажилтны сургалт”-ын агуулгад тогтвортой хөгжлийн талаарх ойлголт сэдвийг нэмж, Тогтвортой хөгжлийн хэлтсээс 7 хоног бүр 2 удаа сургалт орж эхлэв.



Нийт компанийн хэмжээнд “Нэг удаагийн хэрэгслийн хэрэглээг халах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэн, байнгын хэрэгслүүд болон аяга таваг угаагч, ариутгагч, бусад шаардлагатай бүтээгдэхүүнийг 5 байршилд байршуулав.



Азийн Хөгжлийн Банктай “Уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төсөл”-ийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны гэрээг үзэглэв.



Хятадын хөдөө аж ахуйн олон улсын хамтын ажиллагааг дэмжих CARIAC байгууллагаас Хятад улсын Бээжин хотноо зохион байгуулсан “Global Sustainable Natural Fibers” хуралд амжилттай оролцов.



Тогтвортой хөгжлийн зөвлөх үйлчилгээний хүрээнд SBC байгууллагатай хамтран “Тогтвортой хөгжил ба маркетинг”, PWC байгууллагатай хамтран “Олон улсын хуулийн чиг хандлага” сэдэвт сургалт зохион байгуулав.



НҮБ-ын суурин төлөөлөгч Тапан Мишра Говь ХК-д хүрэлцэн ирж Гүйцэтгэх захирал Б.Амарсайхантай ажил хэргийн уулзалт хийсэн бөгөөд манай байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг сайшаан үзэж, цаашид Монгол малчдын хөгжил, Монгол малын үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжийн талаар хэлэлцэв.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсад Азийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан “Workshop on Green Business Models”-д Говь ХК-аас амжилттай оролцож Тогтвортой ногоон бизнесийн моделийг хэрхэн нэвтрүүлэх талаар суралцлаа.



Байгалийн Ширхэгт 2024 олон улсын хурлын салбар чуулганы үеэр ноолуурын үйлдвэрлэлд эмэгтэйчүүдийн оролцооны тэгш байдал, өрхийн амьжиргаанд болон ашиг тус хүртэхэд оруулж буй хувь нэмрийг хүндэтгэн үнэлдэг **“Шилдэг малчин эмэгтэй”** шагналын ивээн тэтгэгчээр оролцов.



Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүд болон удирдлагууд дараах агуулгын хүрээнд сургалтад хамрагдав.

- Уур амьсгалын өөрчлөлт, үр нөлөөг бууруулах тогтвортой хөгжлийн бодлого;
- Нийгмийн хариуцлагын бодлого төлөвлөлт, хүний эрх жендерийн асуудал;
- Тогтвортой бүтээгдэхүүн хөгжүүлэлт, олон улсын чиг хандлага,

БАЙГАЛЬ ОРЧИН



Байгууллагын хүлэмжийн хийн ялгарлыг хамрах хүрээ - 1,2,3 болон бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн түвшинд (LCA) тооцоолж эхлэв.



Говь ХК, Гоёо ХХК-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 5 жилээр батлуулав.



Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу улирал бүр хийгддэг хөрс, агаарын мониторинг хийгдэв.

- Хөрсний шинжилгээг MNS:5850 стандартын үзүүлэлтийн дагуу нийт 5 цэгээс микробиологи, хүнд металлыг тодорхойлох шинжилгээний 2 төрлөөр
- Агаарын шинжилгээг MNS:4585 стандартын дагуу 5 цэгээс үзүүлэлтүүдийг хянаж зөвшөөрөгдөх хэмжээнд хэвийн үзүүлэлтийг хангав.



Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх, үйлдвэрлэх ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 5 жилээр авав.



“Үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламж шинэчлэн барих төсөл”

Говь ХК нь 2024 онд байгаль орчны хуулийн нийцэл болоод тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд хийсэн томоохон хөрөнгө оруулалтуудын нэг нь үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламж шинээр барих төсөл юм.



Тус шинэ цэвэрлэх байгууламж нь хоногт 228 м.куб бохир ус хүлээн авах хүчин чадалтай, MNS 6561 стандартын дагуу L2 түвшний MBBR технологи бүхий, бүрэн автомат байхаар төлөвлөж байна.



Хугацаа дууссан химийн бодисыг устгуулах шаардлагыг хүргүүлж, эрх бүхий байгууллагаар устгуулан, хяналт хийв

НИЙГЭМ

"Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"



"Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-д хамрагдсан малчдаас татан авсан ноолуураар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Европын зах зээлд "Responsible Collection" нэрээр борлуулж эхлэв.



Төсөлд хамрагдсан малчдаас ямааны нас, хүйсээр ангилсан дээж авах ажлыг хийж гүйцэтгэв. Тухайн дээжийг лабораторийн аргаар чанарын шинжилгээ хийж, үр дүнг тайлагнах ажил хийгдэж байна.



Төсөлд хамрагдсан малчдын гараас шууд ноолуур худалдан авах ажлыг 2 дахь жилдээ амжилттай хийж гүйцэтгэлээ. Ойролцоогоор 10 тонн ноолуур татан авалт хийснээр малчдын орлого нэмэгдэх үндэс суурь нь болж байна.



Малчдад зориулан "Жендерийн эрх тэгш байдал" сэдэвт сургалт зохион байгуулж, "Жендерийн хүчирхийлэл"-ийн талаарх зурагт хуудас тараав.



Төсөлд хамрагдсан Баянхонгор аймгийн Жинст болон Хөвсгөл аймгийн Их-Уул сумдад Говь ХК-ийн ухнын сууринд ухна болон хашаа хороонд шимэгдэх өвчлөлөөс сэргийлэх угаалга ариутгал хийв. Мөн малын эрүүл мэндийг сахиж төслийн малчин өрхүүдэд ариутгалын бодис тараав.



НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй АДАПТ төслийн ажлын хэсэгтэй хамтран Ховд, Завхан, Сүхбаатар, Дорнод аймгуудын хоршоодод ноолуурын чанар стандарт шаардлагыг танилцуулав.



АДАПТ төслийн хүрээнд зохион байгуулагдсан "Төр - хувийн хэвшлийн түншлэл - 2024" үзэсгэлэнгийн үеэр чанар стандартын шаардлага хангасан түүхий эдийг зах зээлийн үнээр тогтвортой нийлүүлэх чиглэлээр Говь ХК болон төслийн шилдэг хоршоод хамтран ажиллах санамж бичиг байгуулав.



Тус төслийн үйл ажиллагааг баримтжуулсан видео нэгтгэн контент бүтээн олон нийтэд танилцуулахад бэлтгэсэн.

НИЙГЭМ

“Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө”



"Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-ний хүрээнд түүхий эд бэлтгэн нийлүүлэгч хоршоодын төлөөлөлтэй "Тогтвортой түүхий эд" сэдэв дор уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.



"Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-ний хүрээнд Хан-Уул дүүргийн 3-р хороонд “Говь ХК-ийн мэдээллийн самбар” байршуулж, иргэдэд ил тод, хүртээмжтэй мэдээлэл хүргэх боломжийг нээв.



"Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-ний хүрээнд Хан-Уул дүүргийн 3-р хорооны иргэд оршин суугчдад “Говь ХК-ийн нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөллийг үнэлэх журам”-ын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хүргэв.



УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



Говь ХК нь Олон улсын **"OEKO-TEX STANDARD 100"** гэрчилгээг Монголд анх удаа бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авсан бөгөөд энэхүү стандарт нь Говь ХК-ийн бэлэн бүтээгдэхүүний гол материал болох ноолууран утас болон товч зэрэг бусад туслах материалууд **хүний эрүүл мэнд болон арьстай шууд хүрэлцэхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, харшил үүсгэхгүй** болохыг илтгэнэ.

Манай компани Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Нэгдсэн удирдлагын тогтолцооны:

-ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандарт

-ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт

-ISO 9001:2025 Чанарын удирдлагын тогтолцооны стандартын шалгуурыг бүрэн хангаж, олон улсын SGS баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээг гардан авсан билээ.

Бид **2024** онд гурав дахь жилдээ амжилттайгаар магадлан гэрчилгээг амжилттай баталгаажууллаа.

Говь ХК нь түүхий эд болох ноолуурыг органик хэмээн баталгаажуулахын тулд **USDA/NOP** Олон улсын стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Бид **2024 оны 7-р сард** "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийн малчидтай хамтран зөвлөх үйлчилгээгээр "Зөрүүний шинжилгээ" хийн залруулах арга хэмжээний төлөвлөлтийн гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.

НИЙЦЛИЙН УДИРДЛАГА

ЖУРМЫН НИЙЦЭЛ

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг журмуудыг хэрэгжихүйц хүртээмжтэй болгож, ажилтанд үүсдэг хүндрэлийг багасгах, процессыг хялбаршуулан шинэчлэн сайжруулахтай зорилготой **журмын нийцлийн ажлыг эхлүүлэв.**

ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМЭЭР ИРСЭН МЭДЭЭЛЭЛ

Эх сурвалж	Төрөл	Тоо
<ul style="list-style-type: none"> Шүгэл үлээх системээр – 25 Бичгээр - 1 Утсаар – 7 Бусад сувгаар – 4 	Санал хүсэлт	9
	Харилцааны зөрчил	13
	Хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөрчил	5
	Хувь хүний эрхэд халдсантай холбоотой	2
	Ажлын байрны дарамт, хавчлагатай холбоотой зөрчил	1
	Ялгаварлан гадуурхахтай холбоотой зөрчил	1
	Ёс зүйн кодтой холбоотой	2
	Мөнгө, бараа материал, бусад хөрөнгийн зүй бус ашиглалттай холбоотой	2
	Дотоод дүрэм, журам зөрчсөнтэй холбоотой	1
Хүлээн авах шаардлага хангаагүй	1	
Нийт: 37	Шийдвэрлэсэн байдал: 100%	

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- Эрсдэлийн удирдлагын баг шинээр томилогдов.
- Нийт байгууллагын хэмжээнд **424** эрсдэлийг эрсдэл удирдах хариу арга хэмжээний төлөвлөлтийн дагуу амжилттай удирдаж, хагас жилийн мониторингоор **289** эрсдэл үлдсэн ба нийт эрсдэлийн түвшин **7** онооноос **4** оноотой **ДУНД** түвшинд хүрч буурав.
- Хагас жилийн эрсдэлийн үнэлгээгээр шинээр **104** эрсдэл нэмэгдэж бүртгэгдсэнээр нийт **393** эрсдэлийн түвшин дундаж түвшин **7** оноотой болов. Цаашид эрсдэл удирдах төлөвлөлтүүдийг шинэчлэн эрсдэлүүдийн түвшинг бууруулахаар зорин ажиллана.
- Эхний хагас жилийн байдлаар нийт 2 удаагийн гэнэтийн эрсдэлийн үнэлгээ хийв. Тухайлбал "Animal welfare"-тай холбоотой гэнэтийн эрсдэлийн үнэлгээ хийж, жагсаал цуглааны үед мөрдөх зааварчилгааг батлуулан Герман дахь дэлгүүрийн ажилтнуудад хүргүүлэв. Мөн зудтай холбоотой түүхий эдийн хомсдолын эрсдэлийн үнэлгээ хийв.
- Эрсдэлийн удирдлага болон Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны менежментийн хувьд байгууллагын мэдлэг ойлголтыг сайжруулах сургалтуудыг хоёрдугаар хагас жилд зохион байгуулахаар төлөвлөж байна.
- Ёс зүйн нийцлийн эрсдэлд илүү нарийвчилсан шинжилгээ хийн, анхаарал хандуулан анхаарч ажиллаж байна.
- "Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам"-ын танилцуулгыг нийт ажилтнуудад хүргэв. Бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа /БТҮА/-ны 5 төлөвлөгөөг боловсруулах багуудын томилгоог хийн, багуудад БТҮА менежментийн талаар болон Говь ХК-ийн БТҮА бодлого, журмын танилцуулгыг хийв. Эдгээр төлөвлөгөө боловсруулах багууд нь 7 хоног бүр тогтсон цагт уулзалт хийж байна.

ЗОРИЛТ: ОСОЛ-О БАЙХ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИНГҮЙ БАЙЖ, АЖИЛТНУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХЭВЭЭР ХАДГАЛАХ, ЧАНАРЖУУЛАХ

Хугацаа алдсан гэмтлийн давтамж	Тохиолдлуудыг *1,000,000 Ажилласан хугацаа /цаг/	LTI-давтамж
	0*1,000,000/6,385,200 хүн/ц	0.0

Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан өдөр:	481 өдөр /1,650 ажилтнаар/
Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан цаг:	6,385,200 хүн/ц
Тоолж эхэлсэн огноо:	2023.05.12
Сүүлийн огноо:	2024.09.30

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Хөдөлмөрийн сайдын а/173 тоот тушаалын дагуу хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий мэдлэгийн болон эрх олгох сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

2024 оны 09 сарын 30-ны байдлаар нийт давхардсан тоогоор нийт **2,726** ажилтанд, **16,479 хүн/цаг** сургалт орсон.

“МКЛ” СУРГАЛТЫН ТӨВ

Сургалтын хувиар

Огноо	Сургалтын нэр	Төрөл	Цаг
4-р сарын 19	Гуурын арванд оператор Сараат ачаагчдын оператор	Мэргэжлийн олголт Болсон дагалт Мэргэжлийн олголт Болсон дагалт	9:00-12:00 13:00-16:00
4-р сарын 23	Колонд бүрэн бүтэн байдалд ажиллагаа Колонд явца салгуурын үеийн аюулгүй ажиллагааг эргэлдүүлэх	Мэргэжлийн олголт Болсон дагалт	9:00-12:00
	Колонд ажиллагааг амжилтаар хийжээ Даралтат салын бүрэн бүтэн байдалд ажиллагааг		
4-р сарын 24	Даралтат салын ажиллагааг амжилтаар хийжээ Даралтат салын ажиллагааг амжилтаар хийжээ	Мэргэжлийн олголт Болсон дагалт	13:00-16:00
	Даралтат салын ажиллагааг амжилтаар хийжээ Даралтат салын ажиллагааг амжилтаар хийжээ		
4-р сарын 24	Даралтат салын ажиллагааг амжилтаар хийжээ	Давтан	9:00-10:30





Ноолуур татан авалтын үед ажилтнуудыг хачигт халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор анхан шатны үйлдвэр, түүхий эдийн нярав, чанар баталгаажуулалт, жолооч, лабораторийн **23 ажилтныг** хачигны вакцинд хамруулав.



Говь ХК-ийн Үйлдвэрчний эвлэл Уламжлалт анагаах ухааны төв хүрээлэнтэй хамтран 2024 онд эмчилгээ, сувилгаа шаардлагатай ажилтнуудаа эмийн бус эмчилгээнд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх зорилгоор жил бүр **60 ажилтнаа** УБ рашаан сувилалд хэвтүүлэн сувилуулж байна.



Ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих зорилгоор 1 улиралд давхардсан тоогоор **334 ажилтанд 22,965 ширхэг** эрдэс нөхөх бүтээгдэхүүн олгов.



Жил бүр зохион байгуулагддаг ХЭМАБ аяныг амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд “Ажлын аюулын дүн шинжилгээ”, “Safety share”, “Контент бүтээх тэмцээн”, “Чадварлаг хамт олон” уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулав.



Ундны усны шинжилгээг **MNS 9000:2018** стандартад нийцүүлэн нийт **69** цэгт шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжилгээний үр дүн нийт 95.6% нь унд эрүүл ахуйн усны стандартад нийцсэн цэвэр аюулгүй, нянгийн бохирдолгүй байсан.



2024 оны эрүүл мэндийн хугацаат үзлэгийг 2 ээлжээр хуваарилан хамруулахаар төлөвлөсөн. 3-р улирлын байдлаар нийт **657** ажилтныг хамруулан зохион байгууллаа.



Ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр үйлдвэрийн орчны хяналтыг Химийн бодисын хяналт, Өндөр эрсдэлтэй ажилбарын хяналт, өдөр тутмын хяналт, гал болон тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны хяналтыг тогтмол тавьж ажиллаж байна.



Говь ХК нь ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн нөхцөлийн хэвийн бусын хугацаат үзлэгт ажилтнуудаа хамруулж эхлэв. Одоогоор нийт **46** ажилтан хамрагдсан.



Ажилтныг чадавхжуулах чиглэлээр ХАБЭМ-н төвтэй 2 ХЭМАБ-н инженер, 2 эрүүл ахуйч ХАБЭА сургагч багшийн сургалтад хамруулав. Түүнчлэн ISO стандартын тэргүүлэх аудиторын сургалтад 2 ажилтан хамруулав.



Бид нийгмийн хариуцлагын хүрээнд "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-тэй хамтран 2024.09.03-ны өдөр **ДОНОРЫН ӨДӨРЛӨГ** зохион байгууллаа.

Нийт ажилтны тоо



1,706




Эрэгтэй - **30%**
Дундаж нас: **32**



Эмэгтэй - **70%**
Дундаж нас: **37**

Удирдлагын баг



Дунд түвшний удирдлага



Эрэгтэй **40%**



Эмэгтэй **60%**

Байршлаар:



Монгол - **1,693 (99%)**

- Улаанбаатар хот **1,660**
- Дархан **3**
- Хэнтий **30**



Олон улс - **13 (1%)**

- АНУ **1**
- Европ **12**

Хүүхэд асрах чөлөөтэй ажилтан



329

Ажилтнуудын дундаж нас



35

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ



Замын хөдөлгөөний түгжрэлээс сэргийлэх, ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 3 дахь жилдээ ажлын **уян хатан цагийн системийг** оффисын **+500 ажилтнуудад** хэрэгжүүлж байна.



Ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор сүлжмэлийн үйлдвэрийн нярай болон цэцэрлэгийн насны хүүхдүүдтэй сүлжмэл бүтээгдэхүүний **24 оёдолчныг богиносгосон цагаар** ажиллуулж байна.



Бид ажилтны бие, сэтгэл зүй, санхүүгийн эрүүл мэндийг дэмжих “Health at Gobi” бодлогын хүрээнд МИГ даатгал ХХК-тай хамтран эрүүл мэндийн даатгалд одоогийн байдлаар нийт ажилтнуудын 50 хувь буюу 637 ажилтнуудаа болон тэдний гэр бүлийг сайн дураар, хөнгөлөлттэй үнийн нөхцөлөөр давхар хамрууллаа.

Ингэснээр, эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, хэвтэн эмчлүүлэх болон гэрээр эмчлүүлэх гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа энэхүү даатгалын үйлчилгээг ашиглан цаг алдалгүйгээр санхүүгийн асуудлаа шийдэж, болзошгүй эрүүл мэндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болж байна.

МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР



Хэнтий салбар үйлдвэрийн чадамжийн гэрчилгээ олгох сургалт

Бид Хөнгөн аж үйлдвэрийн салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх зорилгоор Монгол Солонгосын Политехникийн Коллеж (МСПТК)-той хамтарсан санамж бичиг байгуулсан билээ. Энэхүү санамж бичгийн хүрээнд Хэнтий аймаг дахь салбар үйлдвэрийн 30 ажилтанд Сүлжмэл бүтээгдэхүүний оёдолчин /кеттельчин/ мэргэжлээр чадамжийн гэрчилгээ олгох сургалт зохион байгууллаа.



МСПТК-той хамтарсан "Мэргэжилтэй ажилтан" 1 жилийн ангийн сургалт

МСПТК-той байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд мэргэжилтэй ажилтан болон чадамжийн гэрчилгээтэй ажилтнуудыг бэлтгэж, сургах ажлуудыг үе шаттай зохион байгуулж, 2024-2025 оны хичээлийн жилд "Сүлжмэлийн үйлдвэрлэлийн технологи" болон "Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл"-ийн ангид 30 ажилтнаа суралцуулж байна. Ажилтнуудыг суралцах хугацаанд цалинтай ажиллах нөхцөлөөр хангах ба цаашид мэдлэгээ ахиулж мэргэжилтэй ажилтан болох боломжтой.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

1 АЖИЛТАНД
НОГДОХ СУРГАЛТЫН
ХҮН ЦАГ



1.32 хүн/цаг

НИЙТ СУРГАЛТЫН
ЗАРДЛЫН
ЗАРЦУУЛАЛТ



288.7 сая

СУРГАЛТЫН ТОО

279

СУРГАЛТАД
ХАМРАГДСАН
АЖИЛТНЫ ТОО

2,093

Гадаад орны сургалт

- 6 удаагийн сургалт
- 14 ажилтан
- Зардал: 36.3 сая төгрөг

Гаднын байгууллагын
сургалт

- 68 удаагийн сургалт
- 226 ажилтан
- Зардал – 325.3 сая төгрөг

Дотоод сургалт

- 193 удаа сургалт орсон
- 1,818 ажилтан хамрагдсан
- Зардал 0 төгрөг

Scholarship
хөтөлбөрийн сургалт

- Бакалаврын зэргийн 4 жилийн сургалт
- 5 ажилтан хамрагдсан
- Зардал 20,117,086 төгрөг

Хэнтий салбар
үйлдвэрийн сургалт

- Чадамжийн гэрчилгээ олгох 12 удаагийн 96 цагийн сургалт
- 30 ажилтан хамрагдсан
- Зардал 6,900,000 төгрөг

ИДЭВХЖҮҮЛЭЛТ БОЛОН ОЛОН НИЙТИЙН АЖЛУУД



3x3 САГСАН БӨМБӨГИЙН
ТӨРӨЛД АВАРГАА
ТОДРУУЛЛАА



2023 ОНЫ ШИЛДЭГ
АЖИЛТНУУД ШАГНАЛЫН
АЯЛАЛДАА ГАРЛАА



“ГОВЬ”-ИЙН АХМАД ГИШҮҮН
ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛ
ХҮРТЛЭЭ



НИЙТ 1,243 ХҮНД
ҮЙЛДВЭРИЙГ
ТАНИЛЦУУЛЛАА.



ГЭР БҮЛИЙН
ӨДӨРЛӨГҮҮДИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



МЭРГЭЖЛИЙН БАХАРХЛЫН
ӨДРҮҮД



ЭЭРМЭЛИЙН ҮЙЛДВЭРИЙН
АЖИЛТНУУД ЯПОН УЛСЫГ
ЗОРИЛОО



GOBI LEADERS MEETING



БАЯЛАГ БҮТЭЭГЧДИЙНХЭЭ УР ЧАДВАР, ХӨДӨЛМӨРИЙГ
ҮНЭЛСЭН ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭ



ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ
ТЭМЦЭЭН




E-SPORT ТЭМЦЭЭН




УР ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ
НАСКАТНОН ТЭМЦЭЭН



43 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫГ ТОХИОЛДУУЛАН ШИЛДЭГ
АЖИЛТНУУДАА НУРА МОНГОЛИА ЭРХИЙН БИЧИГ, НИЙТ
АЖИЛТНУУДАА ЦЭЦЭГТ МЭНДЧИЛГЭЭ ӨГЛӨӨ.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



НИЙТ ГАРГАСАН
ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

24,868

2024.09.30-ны байдлаар

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2023.12.31		2024.09.30	
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
Таван Богд Холдингс ХХК	400,140,072	51.29%	681,267,736	87.33%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%	-	-

Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани юм. Таван Богд Групп нь 22 охин компани, 3 хөрөнгө оруулалттай компани, нийт 12,000 гаруй ажилтантайгаар бизнесийн 8 үндсэн чиглэлээр салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын манлайлагч групп компани юм.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн дарга,
Эрсдэл, аудитын хорооны гишүүн,
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

СЭЗИС, Бизнес удирдлагын
тэнхимийн профессор



Д.ХҮРЭЛБААТАР

Нэр дэвшүүлэх хорооны
дарга, Цалин урамшууллын
хорооны дарга



А.ЖАРГАЛМАА

Эрсдэл, аудитын хорооны гишүүн,
Цалин урамшууллын хорооны гишүүн

GAPE, ACCA ахлах багш,
хөтөлбөрийн удирдагч



Б.ЦЭЭНЯМ

Anand Resource LLC,
Ерөнхий менежер

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



**Цагаачийн
БААТАРСАЙХАН**

Нэр дэвшүүлэх хорооны
гишүүн

Таван Богд Группийн
Ерөнхийлөгч



**Цогтгэрэлийн
ОРГИЛБОЛД**

Говь ХК-ийн
Тэргүүн дэд захирал,
Говь Кашмер Европ ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



**Дашдаваагийн
ХУЛАН**

Таван Богд Группийн
ТУЗ-ийн дарга



**Нямаагийн
МӨНХБАТ**

Эрсдэл, аудитын хорооны
гишүүн

Таван Богд Холдингс ХХК-ийн
Санхүү удирдлага хариуцсан
захирал



**Баатарсайханы
АМАРСАЙХАН**

Говь ХК-ийн
Гүйцэтгэх захирал

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

ТУЗ-ийн ердийн гишүүн
Э.Пүрэвлхам өөрийн хүсэлтээр
чөлөөлөгдсөн тул 2024 оны 09-р
сарын 10-ны ТУЗ-ийн шийдвэрээр
2025 оны ХЭХ хүртэл ТУЗ-ийн хараат
бус гишүүнээр Б.Цээнмыг түр
томилсон.

Эрсдэл, аудитын хороо

Чиг үүрэг:

- Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх,
- Дотоод хяналт, комплаенс болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх,
- Хараат бус аудитын байгууллагатай харилцан, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах.

Бүрэлдэхүүн:

Хорооны дарга:
А.Жаргалмаа

Гишүүд: Д.Гэрэлмаа
Н.Мөнхбат

Нэр дэвшүүлэх хороо

Чиг үүрэг:

- Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах,
- ЭБАТ-уудын ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих,
- ЭБАТ-уудын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, чиг удирдлагаар хангах.

Бүрэлдэхүүн:

Хорооны дарга:
Д.Хүрэлбаатар

Гишүүд: Д.Гэрэлмаа
Ц.Баатарсайхан

Цалин урамшууллын хороо

Чиг үүрэг:

- ЭБАТ-уудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлон хэрэгжилтэд хяналт тавих,
- Компанийн хэмжээнд баримтлах Цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих.

Бүрэлдэхүүн:

Хорооны дарга:
Д.Хүрэлбаатар

Гишүүд: А.Жаргалмаа



Гүйцэтгэх
захирал
Б.АМАРСАЙХАН



Тэргүүн дэд захирал
/Гадаад, экспорт
борлуулалт/
Ц.ОРГИЛБОЛД



Тэргүүн дэд захирал
/Борлуулалт/
Б.АРИУНАА



Дизайн,
үйлдвэрлэл
хариуцсан
дэд захирал
Б.БОЛОРМАА



Гадаад
борлуулалт
хариуцсан
дэд захирал
О.МИШЭЭЛ



Санхүү
удирдлага
хариуцсан
захирал
Г.БАЯРБАТ



Мэдээлэл
технологи
хариуцсан
захирал
Б.ЭРДЭНЭ



Хүний нөөц
хариуцсан
захирал
Т.ИЧИНХОРЛОО



Үйлдвэр
удирдлага
хариуцсан
захирал
М.БОЛОРТУЯА



Дизайн
хөгжүүлэлт
хариуцсан
захирал
А.УЧРАЛ



Мерчендайзинг
хариуцсан
захирал
О.ЦЭНГЭЛ



Экспортын
борлуулалт
хариуцсан
захирал
Г.АНУДАРЬ



Санхүү
бүртгэл
хариуцсан
захирал
Д.СОДГЭРЭЛ



Нийцэл
хариуцсан
захирал
Б.ЧИНГҮҮН



Хуулийн
хэлтсийн
дарга
Ц.ЦАСЧИХЭР



ТУЗ-ийн
Нарийн
бичгийн
дарга
М.СЭЛЭНГЭ




Дотоод
аудитын
хэлтсийн дарга
Ц.УРАНЧИМЭГ

Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ **2024.09.30**-ны өдрийн хаалтын ханшаар **198.9** тэрбум төгрөг байна.

Нэгж хувьцааны дундаж ханш **262.94** төгрөг (▼ 0.4%)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.09.30	Өөрчлөлт %
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төгрөг/			
Хаалтын үнэ	273.59	255.01	-6.8%
Хамгийн их үнэ	350.00	283.98	-18.9%
Хамгийн бага үнэ	240.69	253.84	5.5%
Дундаж үнэ	263.90	262.94	-0.4%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /ширхэг/			
Хамгийн их /өдөрт/	7,500,000	257,495,975	3333.3%
Хамгийн бага /өдөрт/	179	322	79.9%
Дундаж /өдөрт/	62,704	1,435,517	2189.3%
Нийт	15,676,081	268,441,716	1612.4%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төгрөг/			
Хамгийн их /өдөрт/	2,625,000,000	65,661,782,758	2401.4%
Хамгийн бага /өдөрт/	52,805	85,264	61.5%
Дундаж /өдөрт/	18,985,172	366,158,747	1828.7%
Нийт	4,746,292,927	68,471,685,758	1342.6%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/	213,430,978,875	198,936,488,625	-6.8%



№	Гарчиг	Авбал зохи оноо	2023.12.31		2024.06.30	
			СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	91.7%	11	91.7%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90.0%	10	100.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100.0%	6	100.0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100.0%	6	100.0%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100.0%	8	100.0%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100.0%	6	100.0%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100.0%	8	100.0%
8	Компанийн соёл	6	6	100.0%	6	100.0%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100.0%	10	100.0%
Нэгдсэн дүн		72	70	97.2%	71	98.6%

Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг 2024 оны 06-р сарын 30-ны өдрийн байдлаар ТУЗ-ийн ажлын алба үнэлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг Санхүүгийн зохицуулах хороо хянан баталгаажуулсан болно.

Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь **2024 оны эхний хагас жилийн байдлаар 98.6% буюу засаглал хэвийн, эрсдэлгүй** гэж үнэлэгдсэн байна. Энэ нь 2023 оны жилийн эцсийн үнэлгээнээс 1.4% өссөн үзүүлэлт бөгөөд бид Монгол улс дахь нээлттэй хувьцаат компаниуд дундаас эхний байранд давтан үнэлэгдсэн.

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай Монголын Хөрөнгийн Бирж болон компанийн цахим хуудаснаас, мөн [энд дарж](#) танилцах боломжтой.



GOVI

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2024 оны 09-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobicashmere.com Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Дотоод: gobi.mn Гадаад: gobicashmere.com
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Б.Амарсайхан /Гүйцэтгэх захирал/
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

1.1.	Санхүүгийн байдлын үзүүлэлт		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН		
		(мян.төг)	
		2023.12.31	2024.09.30
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,491,111	2,609,334
	Дансны ба бусад авлага	8,030,908	29,503,329
	Урьдчилгаа төлбөр	3,173,680	5,173,013
	Бараа материал	142,521,277	155,511,979
		163,216,976	192,797,656
	Эргэлтийн бус хөрөнгө		
	Үндсэн хөрөнгө	130,748,653	139,783,812
	Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,109,747	1,236,636
	Хойшлогдсон татварын хөрөнгө	9,276,559	7,725,066
	Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	6,431,599	5,907,266
		148,566,558	154,652,779
	Нийт хөрөнгийн дүн	311,783,533	347,450,436
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр		
	Дансны ба бусад өглөг	38,880,126	57,983,430
	Гэрээний өр төлбөр	1,672,424	2,909,509
	Богино хугацаат түрээсийн өглөг	964,376	366,067
	Орлогын албан татварын өглөг	1,801,508	3,556,419
	Богино хугацаат зээл	232,559,514	229,801,157
		275,877,949	294,616,582
	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат түрээсийн өглөг	1,321,948	1,072,535
	Урт хугацаат зээл	9,830,059	48,688,128
	Бусад урт хугацаат өглөг	17,036,260	-
	Хойшлогдсон татварын өглөг	7,883,775	7,883,775
		36,072,042	57,644,437
	Нийт өр төлбөрийн дүн	311,949,990	352,261,019
	Эзэмшигчдийн өмч		
	Хувьцаат капитал	780,113	780,113
	Дахин үнэлгээний нэмэгдэл	44,568,540	44,568,540
	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(10,662,273)	(10,207,967)
	Хуримтлагдсан алдагдал	(34,852,837)	(39,951,269)
		(166,457)	(4,810,584)
	Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	311,783,533	347,450,436

1.2.	Орлогын тайлан		
		"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН	
			(МЯН.ТӨГ)
		2023.12.31	2024.09.30
	Борлуулалтын орлого	255,650,516	167,916,339
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(131,011,345)	(95,073,091)
	Нийт ашиг	124,639,171	72,843,248
	Бусад орлого	592,777	323,689
	Борлуулалт ба маркетингийн зардал	(73,593,361)	(35,362,676)
	Ерөнхий ба удирдлагын зардал	(19,733,240)	(17,907,797)
	Бусад зардал	(6,980)	(39,238)
	Санхүүгийн орлого	229,734	14,076
	Санхүүгийн зардал	(32,104,979)	(22,867,082)
	Татварын өмнөх алдагдал	23,123	(2,995,781)
	Орлогын татварын өгөөж (зардал)	(6,791,082)	(2,102,652)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	(6,767,959)	(5,098,433)
	Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
	Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	773,737	(454,306)
	Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) орлого	773,737	(454,306)
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	(5,994,221)	(5,552,739)

1.3.	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>				
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН				
	<i>(мян.төг)</i>				
	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
	2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	44,568,540	(11,436,010)	(28,084,878)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(6,767,959)
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	773,737	-
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	773,737	(6,767,959)
	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	44,568,540	(10,662,273)	(34,852,837)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(5,098,433)
	Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	454,306	-
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	454,306	(5,098,433)
	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
	2024 оны 09 сарын 30-ны үлдэгдэл	780,113	44,568,540	(10,207,967)	(39,951,270)
					(4,810,584)
1.4.	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>				
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН				
	<i>(мян.төг)</i>				
				2023.12.31	2024.09.30
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(19,005,294)	(33,871,654)
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(3,862,024)	(15,414,494)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			23,307,356	42,493,668
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ			440,039	(6,792,480)
	Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү			16,153	(89,297)
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			9,034,919	9,491,111
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			9,491,111	2,609,334

2.

Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт

2.

GOBI 

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г 2024 оны 3-р улирлын санхүүгийн тайланг дүгнэх тухай Г

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2024 оны 3-р улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хэлэлцэж, олон нийтэд мэдээлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хагас жилийн тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх

Эрсдэл, аудитын хорооны дарга

Гишүүд






А.ЖАРГАЛМАА

Д.ГЭРЭЛМАА

Н.МӨНХБАТ

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																					
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2023.09.30</th> <th>2024.09.30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Бохир ашгийн маржин</td> <td>48%</td> <td>43%</td> </tr> <tr> <td>Цэвэр ашгийн маржин</td> <td>-2%</td> <td>-3%</td> </tr> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td> <td>0.9</td> <td>0.65</td> </tr> <tr> <td>Бараа материалын эргэц</td> <td>436</td> <td>417</td> </tr> <tr> <td>Хувьцааны нэгж үнэ /₮/</td> <td>297</td> <td>255</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2023.09.30	2024.09.30	Бохир ашгийн маржин	48%	43%	Цэвэр ашгийн маржин	-2%	-3%	Эргэлтийн харьцаа	0.9	0.65	Бараа материалын эргэц	436	417	Хувьцааны нэгж үнэ /₮/	297	255		
Үзүүлэлт	2023.09.30	2024.09.30																				
Бохир ашгийн маржин	48%	43%																				
Цэвэр ашгийн маржин	-2%	-3%																				
Эргэлтийн харьцаа	0.9	0.65																				
Бараа материалын эргэц	436	417																				
Хувьцааны нэгж үнэ /₮/	297	255																				
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																					
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	<ul style="list-style-type: none"> 2024 оны 3-р улирлын байдлаар нийт борлуулалтын орлого өнгөрсөн оны мөн үеэс 1%-ийн өсөлттэй буюу тогтвортой байгаа нь гадаад зах зээлийн бууралтыг үл харгалзан дотоод болон экспорт борлуулалтын өсөлттэй холбоотой байна. Дотоодын зах зээлийн борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 10%-аар өссөн ба үүнд компанийн өнгө төрх шинэчлэлт буюу rebranding хийж, хэрэглэгчдийн ая тухтай үйлчлүүлэх орчныг бүрдүүлэх, борлуулалтыг дэмжих зорилгоор loyalty программ нэвтрүүлж, үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрийн засвар шинэчлэл зэргийг хийсэн нь нөлөөлсөн. Гадаад зах зээлийн хувьд 2024 онд маркетингийн зардлаа бууруулж, илүү брэндинг-д чиглэсэн маркетинг хийж, органик өсөлтийг дэмжин ажиллаж байна. Өөрөөр хэлбэл 2024 онд борлуулалтын өсөлтөөс илүү ашигт ажиллагааг сайжруулахад анхаарч байна. Үүнтэй холбоотой 3-р улирлын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс маркетингийн зардлыг 71%-аар бууруулснаар борлуулалт 59%-аар буурсан ч алдагдлын хэмжээг өнгөрсөн оны мөн үеэс 50%-аар бууруулж чадсан. Олон улсын зах зээлд брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebranding хийж компанийн өнгө төрхөө шинэчилсэн. Бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлэн 100% ноолууран малгайг хөгжүүлэлт хийн 2024 оны 1-р улиралд худалдаанд гаргасан бөгөөд шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн болох Vulcanized Ултай Sneakers болон ноолууран Ballerina-г 2024 оны 2-р улиралд худалдаанд гаргав. Ноолууран Ballerina нь амьсгалдаг технологиор бүтээсэн тул хөлийг халууцуулахгүй агаарыг бүрэн нэвтрүүлэх боломжтойгоороо онцлог тул 																				

		<p>хэрэглэгчдийн таашаалд өндрөөр нийцэж байна. Харин 3-р улиралд хүүхдийн гутал болон 100% хонины ноосон дотортой, арьсан оосор бүхий детальтай Cashmere Mule загвар гэх мэт хэрэглэгчдэд ноолууран гутлыг олон төрлийн загвар дизайнаар танилцуулснаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад борлуулсан гутлын тоо 4.8 дахин нэмэгдсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> • Мөн шинэ төрлийн бүтээгдэхүүн болох ноолууран цүнхний хөгжүүлэлтийг хийн ажиллаж байна. • 2024 оны хувьд ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалж борлуулсан бүтээгдэхүүний өртөг 10%-аар өссөн хэдий ч үйл ажиллагааны бус зардлаа бууруулж чадсанаар хэрэглэгчдэд хүрэх бүтээгдэхүүний үнийг тогтвортой барьж чадсан. • Компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн SAP S/4 HANA ERP системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. • Монгол Улсын хөнгөн аж үйлдвэрийн салбарын түүхэнд анх удаа MES (Manufacturing Execution System) болон Conveyor Belt (дамжлагын систем)-ийг нэвтрүүлэх ажлыг 2024 оны 7-р сараас эхлүүлсэн бөгөөд 2025 оны 1-р сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлэхээр төлөвлөн ажиллаж байна. Ингэснээр сүлжмэл болон оёмолын үйлдвэрүүдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэгж бүтээгдэхүүний үр ашиг, дамжлага дундын мэдээлэл, үйлдвэрлэл дундын чанар, мөшгөлт, үйлдвэрлэлтийн тухайн цаг үеийн өгөгдөл мэдээлэл, хэвийн үйл ажиллагааны хяналт удирдлага зэрэг олон үйл ажиллагааны ашигт ажиллагааг улам сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх үр дүнтэй.
3.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</p>	<p>Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.</p>
4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.</p>	

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Говь ХК-ийн “[Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам](#)”-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг.

Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг.

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ

(мян.төг)

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2023.09.30	2024.09.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	201,880,000	420,714,048
Холбоотой талаас авсан санхүүжилт	231,880,000	450,587,288
Холбоотой талтай хийсэн борлуулалт	178,110	126,881
Холбоотой талаас авсан худалдан авалт	1,373,919	1,577,502
Хүүгийн орлого	195,185	-
Хүүгийн зардал	4,480,753	5,910,245
Түрээсийн орлого	192,032	204,396
Түрээсийн зардал	1,030,538	1,033,790

Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно. Эдгээр холбоотой талуудтай компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах зөвшөөрлийг ТУЗ-ийн 2024 оны 01-р сарын 26-ны [№03 тоот](#) тогтоолоор олгосон болно.


5.

Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг сонгон томилдог бөгөөд ТУЗ нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг хангах, хөрөнгийн өгөөж үр ашгийг нэмэгдүүлэх, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин, оновчтой чиглүүлгээр ханган ажиллахыг зорьдог.

ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл аудитын хороо гэсэн 3 хороо үйл ажиллагаа явуулан тус бүрийн чиг үүргийнхээ дагуу бодлогыг хэрэгжүүлэн компанийн Менежмент багийнхны үйл ажиллагаанд хяналт тавин дүгнэлт өгч, үр дүнгээ ТУЗ-д тайлагнан ажилладаг.

Эрсдэл аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд хараат бусаар дотоод хяналтыг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн харьяанд ТУЗ-ийн ажлын алба ажилладаг бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн мэргэжилтэн гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн ажлын алба нь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын бэлтгэлийг ханган зохион байгуулах, олон нийтэд хүргэх мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах, засаглалын бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, компанийн засаглалын асуудлыг хариуцах, хувьцаа эзэмшигч нарын санал хүсэлтийг хүлээн аван шийдвэрлэх, мэдээ мэдээллээр хангах гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн 10:00 цагт ХААН театр (Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сөүл оффисын 1 давхар)-т амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 12,462,706 (1.60%) саналын эрхтэй 629 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 678,761,381 (87.01%) саналын эрхтэй 74 хувьцаа эзэмшигч буюу нийт 691,224,087 саналын эрхтэй 703 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 88.61% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

Говь ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайлан
2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол
ТУЗ-өөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт
ТУЗ-ийн 2023 оны ажлын тайлан
ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төсөл
ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсөв
ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал шүүмжлэлээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.

ТУЗ-өөс “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2023 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.99%-ийн саналаар батлав.

ТУЗ-ийн гишүүдийн цалинг шинэчлэн тогтоох саналыг 99.99%-ийн саналаар батлав.

ТУЗ-ийн 2023 оны цалингийн төсвийг 99.99%-ийн саналаар батлав.


ТУЗ-ийн гишүүдийг 3 хараат бус гишүүн, 6 ердийн гишүүн буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай томилов.

Хурлын дараах тайлан

Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуулт болон санал зөвлөмжийг хүлээн авч хурлын дараа эргэн холбогдож хариу өгч ажилласан.

2024 оны 05-р сарын 02-ны өдөр ХЭХ-ын материал (110 хуудас хэвлэмэл материал 1 багц, 1 ном, 2 цахим хэлбэрийн материал)-ыг СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнан ажилласан бөгөөд СЗХ-ноос хурлын материалыг хянан хууль, журмын дагуу хуралдсан болохыг баталсан албан бичгийг 2024 оны 06-р сарын 27-ны өдөр ирүүлсэн.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



Таван Богд Холдингс ХХК

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ТОО

24,868

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2023.12.31		2024.09.30	
	Хувьцааны тоо ширхэг	Хувь	Хувьцааны тоо ширхэг	Хувь
Таван Богд Холдингс ХХК	400,140,072	51.29%	681,267,736	87.33%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%	-	-

Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани юм. Таван Богд Групп нь 22 охин компани, 3 хөрөнгө оруулалттай компани, нийт 12,000 гаруй ажилтантайгаар бизнесийн 8 үндсэн чиглэлээр салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын манлайлагч групп компани юм.

ГОВЬ ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТУХАЙ

Говь ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Холдингс ХХК нь 2024 оны 03-р сард хувьцаа эзэмшлийн хувиа нэмэгдүүлэн компанийн 85.29 хувийг эзэмшигч болсон. Компанийн тухай хууль (КТХ)-ийн 53.2-д заасны дагуу “Таван Богд Холдингс” ХХК-ийн хувьцааны эзэмшил 75 хувийг давсан тул Говь ХК-ийн бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг КТХ-ийн 53 болон 54-р зүйлд заасны дагуу хуулийн хугацаанд хэрэгжүүлэх үүрэг Говь ХК-д үүссэн тул манай компани нээлттэй хувьцаат компанийн хувьд хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн, бусад хувьцаа эзэмшигчдийн эрхийг нь эдлүүлж, тэдний эрх ашгийг хангах зорилгоор ТУЗ-ийн 2024 оны 04-р сарын 19-ний хурлаар “Бусад хувьцаа эзэмшигчдийн Хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх” шийдвэр гаргасан.

Тус шийдвэртэй холбоотой хувьцаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 06-р сарын 05-ны өдрийг дуустал цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авсан.

Дээрх хугацаанд нийт 96 хувьцаа эзэмшигчээс 3,427,017 ширхэг хувьцааг худалдах хүсэлт хүлээн авсан бөгөөд төлбөрийг 2024 оны 06-р сарын 12-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд нь байршуулсан болно.

Шаардах эрхийг хуулийн дагуу хэрэгжүүлсэн тухай тайланг бэлтгэн 2024 оны 06-р сарын 13-ны өдөр СЗХ, МХБ-д хүргэсэн.

ТАВАН БОГД ХОЛДИНГС ХХК ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ДЭЭР ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ САНАЛ ГАРГАСАН ТУХАЙ

Таван Богд Холдингс ХХК нь Говь ХК-ийн хувь эзэмшлээ нэмэгдүүлсэнтэй холбоотой КТХ-ийн 57-р зүйлийн 57.1-д заасны дагуу үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр бусад хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авах саналыг 2024 оны 05-р сарын 27-ны өдрөөс 06-р сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд гаргасан.

Тус хугацаанд Говь ХК-ийн нийт 12,462,347 ширхэг хувьцааг худалдах санал хүлээн авсны дагуу төлбөрийг 2024 оны 07-р сарын 01-ний өдөр бүрэн шилжүүлж, үүргээ биелүүлсэн.

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТ

- ТУЗ-ийн 2024 оны 02-р сарын 28-ны өдрийн [№08 тоот](#) тогтоолоор Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайханыг 2024 оны 02-р сарын 29-ний өдрөөр дуусгавар болгон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлж, 2024 оны 03-р сарын 01-ний өдрөөс эхлэн Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Б.Амарсайханыг томилов.
- ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Пүрэвлхам нь 2024 оны 08-р сард ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэн хүсэлтийг хүлээн авч, Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5 дахь заалт, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.14 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэл хараат бус гишүүнийг түр томилохоор шийдвэрлэсэн. Улмаар 08-р сарын 30-наас 09-р сарын 04-нийг дуустал хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар зохион байгуулсан бөгөөд ТУЗ-ийн 09-р сарын 10-ны өдрийн [№32,33 тоот](#) тогтоолоор ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Пүрэвлхамыг чөлөөлж, Б.Цээнъямыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсон.

КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(мян.төг)

№	Зардлын төрөл	2023.09.30	2024.09.30	Өөрчлөлт %
1	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	21,331	23,861	12%
2	ТУЗ-ийн цалин			
2.1	Үндсэн цалин	116,800	155,133	33%
2.2	Оролцооны цалин	27,450	37,050	35%
2.3	Урамшуулалт цалин		-	
2.4	НДШ	18,305	20,862	14%
	Дүн	162,555	213,045	31%
3	Менежмент багийн удирдлагуудын цалин			
3.1	Үндсэн цалин	1,295,987	1,599,733	23%
3.2	Урамшуулалт цалин	13,000	9,000	-31%
3.3	НДШ	176,451	202,151	15%
	Дүн	1,485,438	1,810,884	22%

Засаглалын бүтэц, үйл ажиллагаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэлтэй Хавсралт дахь үйл ажиллагааны тайлангаас танилцана уу.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Эчнээ санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	4	7	6	45	36	12	15	33
Эрсдэл, аудитын хорооны хурал	3	-	3	18	9	6	9	3
Нэр дэвшүүлэх хорооны хурал	2	1	4	24	14	10	10	4
Цалин урамшууллын хорооны хурал	2	-	-	14	8	6	5	1
Нийт	11	8	13	101	67	34	39	41

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2024 оны 3-р улирлын байдлаар нийт 11 ээлжит хурал, 8 ээлжит бус хурал, 13 эчнээ санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллав.

ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР

Тайлант хугацаанд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 101 асуудлыг хэлэлцэн, 67 шийдвэр гаргаж, 41 тогтоолыг баталсан. Үүнд:

- ТУЗ-өөс 33 тогтоол (дотоод үйл ажиллагаатай холбоотой 22 тогтоол, санхүүжилттэй холбоотой 8 тогтоол, үйл ажиллагаа өргөжүүлэх, хүний нөөцтэй холбоотой 3 тогтоол)
- Эрсдэл, аудитын хорооноос 3 тогтоол,
- Нэр дэвшүүлэх хорооноос 4 тогтоол,
- Цалин, урамшууллын хорооноос 1 тогтоол.

Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 34 санал зөвлөмж, 39 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллав. ТУЗ-ийн шийдвэр болон үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

НОГДОЛ АШИГ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 01-р сарын 26-ны өдрийн [№01 тоот](#) тогтоолын дагуу компанийн 2023 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2023 оны Жилийн үйл ажиллагааны тайлан (монгол, англи хэл дээр);
- 2023 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (монгол, англи хэл дээр);
- 2023 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан;
- 2023 оны Тогтвортой хөгжлийн тайлан;
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан (2023.12.31, 2024.06.30-ны байдлаар монгол, англи хэл дээр);
- 2024 оны 1-р улирал болон эхний хагас жилийн санхүү, үйл

ажиллагааны тайлан (монгол, англи хэл дээр);

- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал;
- Шаардах эрх хэрэгжүүлсэн тухай тайлан.



ХӨНДЛӨНГИЙН АУДИТ
 ТУЗ-ийн 2024 оны 09-р сарын 10-ны №31 тоот тогтоолоор Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийг сонгосон.

ШИНЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД
 Говь ХК нь "Компанийн засаглалын кодексийн хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийг 2022 оны 11-р сард баталсан бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 онд ТУЗ-өөс дараах бодлого, журмыг баталсан. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг 2024 оны 01-р сарын 22-ны Цалин урамшууллын хорооны хурлаар хэлэлцэн баталсан.
- "Цалин, урамшууллын бодлого"-ыг шинэчлэн боловсруулан, Цалин урамшууллын хорооны хурлаар хэлэлцэн, 2024 оны 01-р сарын 26-ны ТУЗ-ийн хурлаар баталсан.
- "Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэн боловсруулж, Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэн, 2024 оны 08-р сарын 09-ний ТУЗ-ийн хурлаар баталсан.

Засаглалтай холбоотой дэлгэрэнгүй тайлан мэдээлэлтэй Хавсралт дахь үйл ажиллагааны тайлангаас танилцана уу.


Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

<p>Овог, нэр: Б.Амарсайхан</p> <p>Албан тушаал: "ГОВЬ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: </p> <p>(Тамга/тэмдэг) </p>	<p>Овог, нэр:</p> <p>Албан тушаал: "..." Аудитын компанийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
---	---

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: 

Огноо: 2024 оны 10-р сарын 17-ны өдөр